

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны дугаар сарын –ний өдөр

Улаанбаатар хот

ЗОХИЦУУЛАХ ҮЙЛЧЛЭЛТЭЙ ХҮНСНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилго хүн амын эрүүл мэндийг дэмжих, халдварт бус өвчлөлийг бууруулж, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чиглэгдэнэ.

1.2.Энэ хуулийн зорилт нь зохицуулах үйлчлэлтэй хүнсийг үйлдвэрлэх, импортлох, худалдаалах, баталгаажуулах, эдгээр үйл ажиллагаанд төрөөс хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хууль, тогтоомж

2.1.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Баяжуулсан хүнсний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Зохицуулах үйлчлэлтэй хүнсийг импортлох болон албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад зааснаас бусад хүнсийг баяжуулахтай холбоотой харилцаанд үйлчилнэ.

3.2.Энэ хууль нь хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, биологийн идэвхит бүтээгдэхүүнд холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёо, тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“зохицуулах үйлчлэлтэй хүнс” гэж хүний бие махбодыг бүхэлд нь эсвэл тодорхой эрхтэн системийн үйл ажиллагааг дэмжих биологийн идэвхит нэгдэл агуулсан ижил төрлийн энгийн хүнснээс илүү эрүүл мэндийн ашиг тус үзүүлэх, өдөр тутмын хүнсний хэрэглээний нэг хэсэг болж хэрэглэгдэх зориулалт бүхий боловсруулсан болон байгалийн гаралтай хүнсийг /тун, капсул болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэлбэртэй бус/;

4.1.2.“баяжуулсан хүнс” гэж Баяжуулсан хүнсний тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.3.“хүнсийг албан бус журмаар баяжуулах” гэж хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн санаачлагаар, сайн дурын үндсэн дээр зах зээлийн эрэлтэд тулгуурлан эрх бүхий байгууллагаас баталсан удирдамжийн хүрээнд хүнс баяжуулах үйл ажиллагааг;

4.1.4.“эрүүл мэндийн мэдэгдэл” гэж тухайн хүнс, эсхүл түүний орц болон эрүүл мэндийн хооронд харилцан хамааралтайг нотолж эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан шошгоны тайлбар мэдээллийг;

4.1.5.“шимт бодисын шим тэжээлийн үйлчлэлийн мэдэгдэл” гэж бие махбодын өсөлт, хөгжил, хэвийн үйл ажиллагаанд тухайн төрлийн шим тэжээлийн бодис /амин дэм, эрдэс бодис/-ын гүйцэтгэх физиологийн үүргийг тайлбарласан мэдээллийг;

4.1.6.“өвчний эрсдлийг бууруулах мэдэгдэл” гэж тухайн хүнс болон түүний бүрэлдэхүүн хэсгийн хэрэглээ нь хүний эрүүл мэндтэй холбоотой тохиолдолд эсхүл өвчин үүсэх эрсдэлийг бууруулах нөхцөлд тэдгээрийн үзүүлэх нөлөөллийн мэдээллийг;

4.1.7.“шимт бодисын агууламжийн мэдэгдэл” гэж эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад дурдсан шим тэжээлийн бодисын хүнсэнд агуулагдах хамгийн их болон хамгийн бага хэмжээг өдөрт авах тун хэмжээтэй уялдуулан тодорхойлсон мэдээллийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗОХИЦУУЛАХ ҮЙЛЧЛЭЛТЭЙ ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА

5 дугаар зүйл.Зохицуулах үйлчлэлтэй хүнсэнд тавих шаардлага, баталгаажуулалт

5.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эрүүл мэндийн мэдэгдэл бүхий зохицуулах үйлчлэлтэй хүнсийг баталгаажуулахад мэргэжлийн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус шинжээчийн баг ажиллана.

5.2.Энэ хуулийн 5.1-т заасан шинжээчийг сонгон шалгаруулах болон шинжээчдийн багийн ажиллах журмын Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

5.3.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь эрүүл мэндийн мэдэгдэл бүхий зохицуулах үйлчлэлтэй хүнсний баталгаажуулахад дараах бичиг баримт, мэдээллийг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ:

5.3.1.баталгаажуулах тухай хүсэлт;

5.3.2.зохицуулах үйлчлэлтэй хүнсний эрүүл мэндийн үйлчлэлийг судалж тогтоосон талаарх нотлох баримт;

5.3.3.эмнэлзүйн /клиник туршилтын дүн;

5.3.4.эрүүл хүн, өвчний урьтал үед байгаа эсхүл, эрсдэлт бүлэгт хамаарах шатанд байгаа хүн тухайн зохицуулах үйлчлэлтэй хүнсийг хэрэглэх хэмжээг тогтоосон баримт;

5.3.5.зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан талаарх баримт;

5.3.6.тухайн хүнс, түүний үйлчлэх бодисын тогтвортой байдлын талаарх мэдээлэл;

5.3.7.тухайн хүнс, түүний үйлчлэх бодисын физик, биологийн шинж чанарын талаарх мэдээлэл;

5.3.8.үйлчлэх бодисыг тодорхойлох чанарын болон тоо хэмжээний шинжилгээний арга, итгэмжлэгдсэн лабораторийн аналитик үр дүн;

5.3.9.үйлчлэх бодисын болон энергийн хэмжээ;

5.3.10.тухайн хүнсийг үйлдвэрлэх арга технологи, тоног төхөөрөмж, чанарын хяналтын систем;

5.3.11.шинжлэх ухааны үндэслэл бүхий баталгаа, нотолгоо;

5.3.12.хуульд заасан бусад.

5.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шинжээчийн багийн дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн мэдэгдэл бүхий зохицуулах үйлчлэлтэй хүнсийг баталгаажуулж, бүртгэх үйл ажиллагааг 3 сар тутамд зохион байгуулна.

5.5.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний шимт бодисын шим тэжээлийн үйлчлэлийн мэдэгдэлд хамаарах бодисын жагсаалт, тун болон уг мэдэгдлийг хэрэглэх, шимт бодисын мэдэгдэл бүхий зохицуулах үйлчлэлтэй хүнсийг баталгаажуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

5.6.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 5.6-д заасан жагсаалтад багтсан эрдэс бодисын төрөл тус бүрээр үндэсний стандарт батална.

5.7.Тухайн хүнсний бүтээгдэхүүн нь эрх бүхий байгууллагаас тогтоосон тун хэмжээ, шаардлагыг хангасан тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүндээ “Шимт бодисын үйлчлэлийн мэдэгдэл”-ийг хэрэглэж болно.

6 дугаар зүйл.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлага

6.1.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний үйлдвэрлэлийг аж ахуйн нэгж эрхлэх бөгөөд Хүнсний тухай хуулийн 10.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

6.1.1. зохицуулах үйлчлэлтэй хүнсийг холбогдох журмын дагуу баталгаажуулж, бүртгүүлсэн байх;

6.1.2. хүнсний сав, баглаа боодол, шошгонд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаас гадна “эрүүл мэндийн мэдэгдэл” болон холбогдох тэмдэг, тэмдэглэгээг тусгах;

6.1.3. тухайн хүнсийг өдөрт хэрэглэх хэмжээ, анхааруулах санамж бүхий шим тэжээлийн үйлчлэлийн мэдэгдлийг холбогдох журам, шаардлагын дагуу бүтээгдэхүүний шошгонд тусгах.

6.2. Зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүний шошгонд эмчилгээний мэдэгдэл буюу “өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “өвчнийг оношлох”, “өвчнийг эмчлэх”, “өвчнийг эдгээх” зэрэг бусад хэрэглэгчийг төөрөгдүүлэхүйц мэдэгдлийг тусгахыг хориглоно.

7 дугаар зүйл. Хүнсийг албан бус журмаар баяжуулах

7.1. Хүнсийг баяжуулах удирдамж, баяжуулагч бэлдмэлийн орц, хэмжээ, тунг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.2. Хүнсийг албан бус журмаар баяжуулах үйл ажиллагааг хуулийн этгээд эрхлэх бөгөөд Хүнсний тухай хуулийн 10.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

7.2.1. эрх бүхий байгууллагаас баталсан удирдамж, хэмжээг баримтлан баяжуулсан хүнс үйлдвэрлэх;

7.2.2. Хүнсний тухай хуулийн 16.1-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн баяжуулагч бэлдмэлийг ашиглах;

7.2.3. Баяжуулсан хүнсний тухай хуулийн 6.3.3-т заасан баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээг хэрэглэх;

7.3. Хүнсийг албан бус журмаар баяжуулсан тохиолдолд баталгаажуулахгүй.

8 дугаар зүйл. Зохицуулах үйлчлэлтэй хүнс импортлох, худалдаалах

8.1. Зохицуулах үйлчлэлтэй хүнсийг импортлоход холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан удирдамж, стандарт, журмыг баримтална.

8.2. Зохицуулах үйлчлэлтэй хүнсийг худалдаалах, импортлоход Хүнсний тухай хуулийн 4.1.4-т заасныг баримтална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗОХИЦУУЛАХ ҮЙЛЧЛЭЛТЭЙ ХҮНСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛАА БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

9 дүгээр зүйл. Зохицуулах үйлчлэлтэй хүнсний талаар төрийн байгууллагын чиг үүрэг

9.1. Засгийн газар зохицуулах үйлчлэлтэй хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих үндэсний хөтөлбөр баталж, хэрэгжүүлнэ.

9.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулах үйлчлэлтэй хүнсний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.2.1.Хүнсний тухай хуулийн 9.1.1-д заасан судалгааны дүнд үндэслэн хүнс баяжуулах удирдамжийг олон улсын эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг баримтлан батлах;

9.2.2.зохицуулах үйлчлэлтэй хүнсэнд агуулагдвал зохих шимт бодисын хамгийн бага болон их хэмжээг тогтоох;

9.2.3.импортын зохицуулах үйлчлэлтэй хүнсний талаар дүгнэлт гаргах;

9.2.4.зохицуулах үйлчлэлтэй хүнсний шошгонд тусгах эрүүл мэндийн үйлчлэлийн мэдэгдлийг батлах;

9.2.5.хүн амыг халдварт бус өвчлөлөөс сэргийлэх, зохицуулах үйлчлэлтэй хүнсний ач холбогдлын талаар иргэдийг мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах.

9.3.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулах үйлчлэлтэй хүнсний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.3.1.зохицуулах үйлчлэлтэй хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар болон хэрэглэх журмыг батлах;

9.3.2.эрүүл мэндийн мэдэгдэл бүхий зохицуулах үйлчлэлтэй хүнсийг баталгаажуулах, бүртгэх журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

9.3.3.зохицуулах үйлчлэлтэй хүнсний үйлдвэрлэл эрхлэгчийг бүртгэж, мэдээллийн сан үүсгэх;

9.3.4.зохицуулах үйлчлэлтэй хүнс үйлдвэрлэгчийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд мэдээлэх журмыг батлах.

9.4.Зохицуулах үйлчлэлтэй хүнс үйлдвэрлэх, импортлох үйл ажиллагаанд хяналт тавих журмыг Эрүүл мэндийн болон Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

11 дүгээр зүйл.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний хэрэглээг дэмжих

11.1.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний ач холбогдол, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл, сурталчилгааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

11.2.Хэрэглэгч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохицуулах үйлчлэлтэй хүнсийг зөвлөмжийн дагуу хэрэглэнэ.

11.3.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний хэрэглээ, үр нөлөөг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 2 жил тутам судалж, үр дүнг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд танилцуулна.

12 дугаар зүйл.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний хяналт

12.1. Зохицуулах үйлчлэлтэй хүнс үйлдвэрлэгч нь эгзэгтэй цэгийн хяналтыг хэрэгжүүлж, бүтээгдэхүүнээ дотоодын хяналтаар баталгаажуулна.

12.2. Зохицуулах үйлчлэлтэй хүнсний үйлдвэрлэл, импорт, худалдаанд тавих хяналтын журмыг мэргэжлийн хяналтын байгууллага батална.

12.3. Зохицуулах үйлчлэлтэй хүнсний үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналтын байгууллагын хүнсний чанар, стандартын улсын байцаагч хяналт тавьж ажиллана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

12 дугаар зүйл. Хууль, тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

12.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

12.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

13.1. Энэ хуулийг оны дугаар сарын –ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.